

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Инженер, технологийн дээд боловсрол төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/27/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Батчимэг Утас: 261740 Цахим хаяг: batchimegda@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгуулага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	25
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ИТДБТ	Инженер технологийн дээд боловсрол төсөл
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОУНТШ	Олон улсын нээлттэй тендер шалгаруулалт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худагдан авах
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТУХ	Төслийн удирдах хороо
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтай дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/323
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 438,282.7 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Боловсролын сайдын тушаалаар Япон Улсад суралцаж байсан 10 оюутантай байгуулсан зээлийн гэрээг цуцалснаас 6 оюутан нь тайлант онд зээлийн эргэн төлөлт хийгээгүй 438,282.7 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй;
- Зээлийн эргэн төлөлт хийгээгүй 4 суралцагчийн мэдээллийг Боловсролын зээлийн санд хүргүүлээгүй зэрэг нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2014 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/308 дугаар тушаалаар батлагдсан "Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосэн, хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам"-ын 2.11 "Төслийн удирдах хороо нь суралцагчийн улирал, жилийн эцсийн сурлагын дүнгийн голч оноо нь гэрээнд заасан дүнг хангахгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр цаашид үргэлжлүүлэн сурах боломжгүй болсон тохиолдолд суралцах үйл ажиллагааг зогсоох саналыг боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын

гишүүнд танилцуулж зохих шийдвэр гаргуулна", 2.12 "Энэхүү журмын 2.11 дахь хэсэгт заасан шийдвэр гарсан суралцагчтай байгуулсан гэрээг цуцалж, суралцсан хугацааны зардлыг буцаан төлүүлнэ", Инженер, технологийн дээд боловсрол төслийн санхүүжилтээр Япон Улсад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 2.1.6 "Суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зээлийн журмын дагуу буцаан төлж барагдуулаагүй нөхцөлд хуулийн байгууллагад хандан зээлийг төлүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн "Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц орон тоог батлах тухай" 174 дүгээр тушаалын дагуу тус төслийн нэгжийг Боловсролын яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлж, ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон.

Төслийн судалгааны тоног төхөөрөмж, лабораторийг шинэчлэх зорилтын хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуульд 2,962,465.4 мянган төгрөг, Монгол Улсын их сургуульд 2,260,672.1 мянган төгрөг, Хөдөө аж ахуйн их сургуульд 2,647,515.7 мянган төгрөг нийт 7,870,653.2 мянган төгрөгийн үнэ бүхий судалгааны болон сургалтын тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна.

Дээр дурдсан асуудлууд нь тайлант үеийн санхүүгийн тайлан, тодруулгад тусгагдсан бөгөөд аудитын санал дүгнэлтэд нөлөөлөхгүй боловч тайлан хэрэглэгчдийн анхааралд онцлон хүргэх шаардлагатай гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал юм. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд аудитын гол асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/07 дугаар тушаалаар Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосен, магистр, докторын хөтөлбөрт 2014-2019 оны хооронд суралцан төгсөж, эх орондоо 5 жил ажилласан 22 оюутны 2,723,363.8 мянган төгрөгийн зээлийн гэрээний үүргийг дуусгавар болгосон.

Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 01/9339 дугаар албан бичгээр төслийн хэрэгжих хугацааг есөн сараар сунгах хүсэлтийг Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад уламжилснаар 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон

хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Тайлант онд төсөл хэрэгжүүлэх нэгж нь нийт 4 багц, 28 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн удирдах хорооны 133 дугаар тогтоолын хавсралтаар батлуулсан. Нийт төлөвлөсөн ажлуудаас 26 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,713,226,354.75	70,982,214,205.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	395,810,426.82	8,656,636.33
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	395,810,426.82	8,656,636.33
3122	Гадаад валют	395,810,426.82	8,656,636.33
31222	Монгол банк дахь харилцах	40,090,020.51	7,452,803.00
31223	Арилжааны банк дахь харилцах	355,720,406.31	1,203,833.33
33	АВЛАГА	1,353,449,713.57	3,665,293,739.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	527,000.00
335	Бусад авлага	1,353,449,713.57	3,664,766,739.23
3351	Байгууллагаас авах авлага	1,353,449,713.57	3,664,766,739.23
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	68,963,966,214.36	67,308,263,830.21
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34600	Урьдчилж гарсан зардал	68,963,966,214.36	67,308,263,830.21
35	БАРАА МАТЕРИАЛ	394,800.00	-
354	Хангамжийн материал	394,800.00	-
35420	Аж ахуйн материал	90,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	304,800.00	-
3	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
392	Биет хөрөнгө	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,513,476.34	25,513,476.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,513,476.34)	(25,513,476.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,492,990.95	15,492,990.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,492,990.95)	(15,492,990.95)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	70,713,621,154.75	70,982,214,205.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	34,000.00	35,715,440.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	34,000.00	35,715,440.00
413	Өглөг	34,000.00	35,715,440.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	34,000.00	1,054,000.00
4136	Бусад өглөг	-	34,661,440.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	34,661,440.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	70,713,587,154.75	70,946,498,765.77
51	Засгийн газрын хувь оролцоо	70,713,587,154.75	70,946,498,765.77
512	Хуримтлагдсан үр дүн	70,713,587,154.75	70,946,498,765.77
51210	Өмнөх үеийн үр дүн	69,445,325,532.93	70,713,587,154.75
51220	Тайлант үеийн үр дүн	1,268,261,621.82	232,911,611.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	70,713,621,154.75	70,982,214,205.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,119,882,614.79	15,698,222,533.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,569,838,414.79	15,698,222,533.17
120	Нийтлэг татварын бус орлого	5,569,838,414.79	15,216,900,433.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,569,838,414.79	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,569,838,414.79	-
120009	Бусад орлого	-	15,216,900,433.17
122	Тусламжийн орлого	-	481,322,100.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	481,322,100.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	481,322,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	481,322,100.00
122	Тусламж санхүүжилтийн орлого	550,044,200.00	-
122111	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	550,044,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,663,795,592.67	7,438,986,968.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,663,795,592.67	7,438,986,968.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,642,422,174.75	7,430,117,155.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,990,509.50	390,300,234.00
210101	Үндсэн цалин	373,990,509.50	390,300,234.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,748,812.50	48,632,275.00
210201	Тэтгэврийн даатгал	31,789,192.5	33,175,375
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,739,905	3,864,900
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,869,952.5	1,955,000
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,869,952.5	1,955,000
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,479,810	7,682,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,400,000.00	4,740,000.00
210304	Байрны түрээс	5,400,000.00	4,740,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,442,911.08	11,191,960.00
210401	Бичиг хэрэг	3,925,909.08	1,883,310.00
210402	Тээвэр, шатахуун	6,400,000.00	8,000,000.00
210404	Ном, хэвлэл	791,696.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,325,306.00	1,308,650.00
2107	Томилолт, зочны зардал	57,875,179.00	6,917,000.00
210701	Гадаад албан томилолт	57,543,758.00	-
210702	Дотоод албан томилолт	-	6,917,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	331,421.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,144,152,326.53	6,968,335,686.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,144,152,326.53	6,968,335,686.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	812,436.14	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	812,436.14	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,373,417.92	8,869,812.80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	8,869,812.80
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	8,869,812.80
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	8,869,812.80
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	8,869,812.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,373,417.92	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,373,417.92	-

Инженер, технологийн дээд боловсрол төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,456,087,022.12	8,259,235,564.93
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	692,880,974.38	890,366,408.73
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	692,880,974.38	890,366,408.73
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,880,706,374.68	8,916,690,362.64
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	961,829,841.38	699,422,760.23
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	918,876,533.30	8,217,267,602.41
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (7)=(4-5)	(1,187,825,400.3)	(8,026,323,953.91)
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(7)	1,268,261,621.82	232,911,611.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,733,499,750.00	15,698,222,533.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,183,455,550.00	15,698,222,533.17
120	Нийтлэг татварын бус орлого	2,183,455,550.00	15,216,900,433.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,183,455,550.00	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,183,455,550.00	-
120009	Бусад орлого	-	15,216,900,433.17
122	Тусламжийн орлого	-	481,322,100.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	481,322,100.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	481,322,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	481,322,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	550,044,200.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	550,044,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	550,044,200.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,504,707,836.55	6,093,890,994.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,504,707,836.55	6,093,890,994.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,483,334,418.63	6,085,021,181.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,956,509.50	390,334,234.00
210101	Үндсэн цалин	373,956,509.50	390,334,234.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,748,812.50	48,105,275.00
210201	Тэтгэврийн даатгал	31,789,192.50	32,648,375.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,739,905.00	3,864,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,869,965.00	1,955,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,869,940.00	1,955,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,479,810.00	7,682,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,400,000.00	4,740,000.00
210304	Байрны түрээс	5,400,000.00	4,740,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,442,911.08	10,797,160.00
210401	Бичиг хэрэг	3,925,909.08	1,793,310.00
210402	Тээвэр, шатахуун	6,400,000.00	8,000,000.00
210404	Ном, хэвлэл	791,696.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,325,306.00	1,003,850.00
2107	Томилолт, зочны зардал	57,875,179.00	6,917,000.00
210701	Гадаад албан томилолт	57,543,758.00	-
210702	Дотоод албан томилолт	-	6,917,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	331,421.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,985,911,006.55	5,624,127,512.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,985,911,006.55	5,624,127,512.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,373,417.92	8,869,812.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,373,417.92	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,373,417.92	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,869,812.80
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,869,812.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(2,771,208,086.55)	9,604,331,538.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН	-	10,181,970,228.07

Инженер, технологийн дээд боловсрол төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫН ДҮН (5)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,181,970,228.07
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,181,970,228.07
222001	Тоног төхөөрөмж	-	10,181,970,228.07
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,181,970,228.07)
14	Бусад эх үүсвэр	692,880,974.38	889,907,659.03
145004	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	692,880,974.38	889,907,659.03
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	944,594,170.19	699,422,760.23
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	944,594,170.19	699,422,760.23
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(251,713,195.81)	190,484,898.80
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,022,921,282.36)	(387,153,790.49)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,418,731,709.18	395,810,426.82
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	395,810,426.82	8,656,636.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	69,445,325,532.93	69,445,325,532.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	69,445,325,532.93	69,445,325,532.93
Тайлант үеийн үр дүн	-	1,268,261,621.82	1,268,261,621.82
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	70,713,587,154.75	70,713,587,154.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	70,713,587,154.75	70,713,587,154.75
Тайлант үеийн үр дүн	-	232,911,611.02	232,911,611.02
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	70,946,498,765.77	70,946,498,765.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	16,353,871,100.00	15,689,352,720.37	664,518,379.63	95.9
12	Татварын бус орлого	16,353,871,100.00	15,689,352,720.37	664,518,379.63	95.9
120	Нийтлэг татварын бус орлого	15,786,000,000.00	15,216,900,433.17	569,099,566.83	96.4
120009	Бусад орлого	15,786,000,000.00	15,216,900,433.17	569,099,566.83	96.4
122	Тусламжийн орлого	567,871,100.00	472,452,287.20	95,418,812.80	83.2
122005	Төсвөөс санхүүжих	567,871,100.00	472,452,287.20	95,418,812.80	83.2
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,353,871,100.00	16,266,991,409.65	86,879,690.35	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,171,871,100.00	6,085,021,181.59	86,849,918.41	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,171,871,100.00	6,085,021,181.59	86,849,918.41	98.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,000,000.00	390,334,234.00	665,766.00	99.8
210101	Үндсэн цалин	391,000,000.00	390,334,234.00	665,766.00	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,875,000.00	48,105,275.00	769,725.00	98.4
210201	Тэтгэврийн даатгал	33,235,000.00	32,648,375.00	586,625.00	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,910,000.00	3,840,950.00	69,050.00	98.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,955,000.00	2,049,284.00	(94,284.00)	104.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,955,000.00	1,884,666.00	70,334.00	96.4
210205	Эрүүл мэндийн даатгал	7,820,000.00	7,682,000.00	138,000.00	98.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,150,000.00	4,740,000.00	2,410,000.00	66.3
210304	Байрны түрээс	7,150,000.00	4,740,000.00	2,410,000.00	66.3
2104	Хангамж, бараа материалын зардал	22,300,000.00	10,797,160.00	11,502,840.00	48.4
210401	Бичиг хэрэг	5,500,000.00	1,793,310.00	3,706,690.00	32.6
210402	Тээвэр, шатахуун	11,000,000.00	8,000,000.00	3,000,000.00	72.7
210404	Ном, хэвлэл	3,200,000.00	-	3,200,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600,000.00	1,003,850.00	1,596,150.00	38.6
2107	Томилолт, зочны зардал	64,484,500.00	6,917,000.00	57,567,500.00	10.7
210701	Гадаад албан томилолт	56,430,500.00	-	56,430,500.00	0.0
210702	Дотоод албан томилолт	7,334,000.00	6,917,000.00	417,000.00	94.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	720,000.00	-	720,000.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,638,061,600.00	5,624,127,512.59	13,934,087.41	99.8

Инженер, технологийн дээд боловсрол төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,638,061,600.00	5,624,127,512.59	13,934,087.41	99.8
22	Хөрөнгийн зардал	10,182,000,000.00	10,181,970,228.06	29,771.94	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	10,182,000,000.00	10,181,970,228.06	29,771.94	100.0
222001	Тоног төхөөрөмж	10,182,000,000.00	10,181,970,228.06	29,771.94	100.0
	Төсвийн тохируулгын дүн		190,484,898.80		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		395,810,426.82		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,656,636.33		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9	9		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Инженер, технологийн дээд боловсрол төсөл нь Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ийн хооронд 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан MON-P11 тоот хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн дагуу 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжиж дуусна.

Инженер технологийн дээд боловсрол төсөл нь Япон улсын Засгийн газрын жилийн 0.2 хувь болон 0.01 хувийн зээлийн хүүтэй, 20 жилийн хугацаанд эргэн төлөгдөх 7.5 тэрбум иенийн хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн 1,000 гаран тооны мэргэжилтэн бэлтгэж, Монгол Улсад инженерийн боловсрол олгодог улсын 3 их сургуулийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлж, сургалтын орчныг шинэчлэн, чанарыг сайжруулах зорилгоор дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Хөтөлбөр 1: Аж үйлдвэрийн салбарт чадварлаг хүний нөөцийг бэлтгэх

- Коосэн хөтөлбөрт 200 оюутан суралцуулах;
- Бакалаврын хамтарсан хөтөлбөрт 320 оюутан суралцуулах.

Хөтөлбөр 2: Коосэн болон Бакалаврын хамтарсан хөтөлбөрийн чанарыг сайжруулах

- ШУТИС-ийн сургалтын 30 хөтөлбөрийг шинэчлэх;
- Коосэн боловсролыг нутагшуулж, дэлгэрүүлэх.

Хөтөлбөр 3: Багшийн сургалт, судалгааны агуулгыг бэхжүүлэх /МУИС, ШУТИС, ХААИС/

- Хамтарсан судалгааны 26 сэдвийг хэрэгжүүлэх;
- Магистрын хөтөлбөрт 50 багш, судлаачдыг суралцуулах;
- Докторын хөтөлбөрт 110 багш, судлаачдыг суралцуулах;
- Зэргийн бус хөтөлбөрт 320 багш, судлаачдыг хамруулах;
- Япон Улсаас 325 зочин судлаачдыг урьж ажиллуулах.

Хөтөлбөр 4: Сургалт, судалгааны тоног төхөөрөмжийг нийлүүлэх /МУИС, ШУТИС, ХААИС/

- Судалгааны тоног төхөөрөмж, лабораторийг шинэчлэх;
- Сургалтын тоног, төхөөрөмж, лабораторийг шинэчлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Инженер, технологийн дээд боловсрол төсөл боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөл хэрэгжүүлэгч нэгж бөгөөд үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын гаргасан тушаал шийдвэр, болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8, 12, 14, 16, 28, 57, 68 дугаар зүйлүүдэд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчидад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам” 215 дугаар тогтоол.

Төслийн удирдах хороо нь ТХН-ийг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдаа холбоо бүхий нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж, төслийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус нэгж бөгөөд 2025 онд 3 удаа хуралдаж, ТХН-ийн үйл ажиллагаатай холбоотой 5 зөвлөмжийг баталж хэрэгжүүлсэн байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үнэллээ.

Боловсролын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас тайлант онд тус төслийн санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлсэнээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа Боловсролын яамны БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-т үндэслэн холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ-ийг боловсруулж, мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төсөл нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,593.1 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	395,810.4	8,656.6	(387,153.8)
Авлага	1,353,449.7	3,665,293.7	2,311,844.0
Урьдчилгаа	68,963,966.2	67,308,263.9	(1,655,702.3)
Хангамжийн материал	394.8	-	(394.8)
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	70,713,621.1	70,982,214.2	268,593.1
Богино хугацаат өр төлбөр	34.0	35,715.4	35,681.4
Хуримтлагдсан үр дүн	70,713,587.1	70,946,498.8	232,911.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	70,713,621.1	70,982,214.2	268,593.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 8,656.6 мянган төгрөг болж, 387,153.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнө онд байгуулсан гэрээт ажлуудын үлдэгдэл төлбөрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 3,665,293.7 мянган төгрөг болж 2,311,844.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд MJEED-B5-20250210 дугаартай олон улсын нээлттэй тендер зарлаж, 4 байгууллагатай гэрээ байгуулан урьдчилгаа 10 хувийн төлбөрийг шилжүүлснээс шалтгаалжээ.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 67,308,263.9 мянган төгрөг болж 1,655,702.3 мянган төгрөгөөр буурсан нь Боловсролын зээлийн сангийн 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/07 тушаалаар 22 оюутны гэрээний үүргийг дуусгавар болгож тэтгэлэг болгон тайлант хугацааны зардлаар тайлагнасангай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны 35,715.4 мянган төгрөгийн үлдэгдэлд 2,900 ширхэг 7 нэр төрлийн сурах бичиг хэвлүүлэх гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 34,661.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад төлөх 1,054.0 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна;

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн орлого өмнөх оноос 9,647,062.0 мянган төгрөг буюу 1.7 дахин өссөн нь тайлант оны батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан МУИС, ШУТИС, ХААИС-ийн сургалт, судалгааны тоног төхөөрөмж, нийлүүлэх 4 дүгээр тендерийн үлдэгдэл төлбөр болон 5 дугаар тендерийн гэрээний урьдчилгаа 10.0 хувийн төлбөрийн шилжүүлгийг хэрэгжүүлэхээр болсноос шалтгаалсан байна.

Инженер, технологийн дээд боловсрол төсөл нь Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "ACOLOUS" төсөвт байгууллагын санхүүгийн программыг ашигладаг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төслийн нэгж нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлийн санхүүжилтээс 23,128,039.1 мянган төгрөг, улсын төсвөөс 556,399.0 мянган төгрөг, нийт зарлагыг 23,684,438.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төслийн нэгжийн төсвийн саналыг Сангийн яамнаас урсгал зардлыг 11,472.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлыг 7,342,039.1 мянган төгрөгөөр бууруулж нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 16,353,871.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөрөнгийн зардлын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй буюу 2025 оны худалдан авах ажиллгааны санхүүжилтийн хуваарьтай холбоотой хөрөнгийн зардлын хэмжээг бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гадаад зээлийн эх үүсвэрээс 15,216,900.4 мянган төгрөгийг санхүүжилт олгогджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 481,322.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 8,869.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,266,991.4 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,435.5 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 2,410.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 11,502.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 57,567.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 13,934.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

						/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	70207	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл	16,353,871.1	16,266,991.4	86,879.7	99.5
1.1	80104	Зээлийн зарцуулалт	15,786,000.0	15,794,539.1	(8,539.1)	100.1
1.2	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	567,871.1	472,452.3	95,418.8	83.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Уг төсөл хэрэгжүүлэгч нэгжийг Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц орон тоог батлах тухай” 174 дүгээр тушаалын дагуу Боловсролын яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлж, ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон.

2. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнуудад унаа, хоолны хөнгөлөлт олгоогүй бөгөөд зөвхөн үндсэн цалингийн зардал гарсан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 5 хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төслийн хэрэгжилтийн нийт түвшин 95.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

Инженер, технологийн дээд боловсрол төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Коосэн хөтөлбөр					
1.1	Бэлтгэл сургалт	2015-2021	200 оюутан	177 оюутан 88.5%	4,696,042.8	4,555,584.9
1.2	Японы коосэн сургуулиудад оюутан суралцуулах	2015-2023			19,643,701.1	19,638,265.6
2	Бакалаврын хамтарсан хөтөлбөрт оюутан суралцуулах;					
2.1	Бэлтгэл сургалт	2016-2020	320 оюутан	292 оюутан 91.5%	3,110,346.1	3,103,891.4
2.2	Японы Их сургуулиудад оюутан суралцуулах	2018-2023			28,321,931.8	28,256,610.9
3	ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх;	2015-2026	30 хөтөлбөр	37 хөтөлбөр 100.0%		
4	Хамтарсан судалгааг хөгжүүлэх					
4.1	Магистрын хөтөлбөрт багш, судлаачдыг суралцуулах;	2015-2026	50 судлаач	37 судлаач 74.0%	5,067,333.9	4,471,037.0
4.2	Докторын хөтөлбөрт багш, судлаачдыг суралцуулах;	2015-2026	110 багш	104 багш 94.5%	16,745,998.2	16,104,785.6
4.3	Зэргийн бус сургалтад багш, судлаачдыг суралцуулах;	2015-2026	320 судлаач	517 судлаач 100.0%	7,305,957.0	4,388,853.4
4.4	Япон Улсаас зочин судлаачдыг урьж ажиллуулах;	2015-2026	325 судлаач	485 судлаач 100.0%	3,887,496.2	2,242,964.1
4.5	Судалгааг хөгжүүлэх сан	2018-2026	20 судалгаа	25 судалгаа 100.0%	2,255,902.8	1,876,904.0
5	МУИС, ШУТИС, ХААИС-ийн сургалт, судалгааны тоног төхөөрөмж, лабораторийг шинэчлэх;	2015-2026	91 лаборатори	91 лаборатори 100.0%	57,116,240.0	47,361,944.8
6	Хөтөлбөрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	2015-2026	1	1 100%	16,309,150.0	15,832,304.8
Дүн				95.0%	164,460,100.0	147,833,146.5

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2023 оны 11 дүгээр сард Боловсрол шинжлэх ухааны сайдын А/478 тоот тушаалын дагуу Төслийн Удирдах Хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 133 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар Инженер, технологийн дээд боловсрол төслийн 5 дугаар ээлжийн буюу 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Тайлант онд MON-P11 тоот зээлийн хэлэлцээрийн дагуу Японы олон улсын албан ёсны тусламжийн зээлийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагааны журмыг баримтлан MJEED-B5-20250210 дугаартай олон улсын нээлттэй тендер зарлаж, шалгаруулалтын үр дүнд байгуулагдсан 5 гэрээний хэрэгжилтийг хангаж

ажиллахаар төлөвлөснөөс гэрээний урьдчилгаа 10.0 хувийн санхүүжилтүүд хийгдсэн байна. Үүнд:

5 дугаар ээлжийн ОУНТШ-аар байгуулагдсан гэрээний хэрэгжилт

Гэрээний мэдээлэл	Гүйцэтгэгч	Гэрээгээр хийгдсэн нийлүүлэлт	Гэрээний үнэ (ам.доллар)	Урьдчилгаа санхүүжилт (ам.доллар)	Үлдэгдэл төлбөр (ам.доллар)
MJEED-B5-20250210-P1 (2025.06.23-2026.03.30)	Интерсайнс ХХК	ХААИС-ийн хамтарсан судалгааны лабораторийн тоног төхөөрөмж	680,000.00	68,000.00	612,000.00
MJEED-B5-20250210-P3 (2025.06.20-2026.03.30)	Грийн Химистри ХХК	МУИС-ийн Байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж	710,391.00	71,039.10	639,351.90
MJEED-B5-20250210-P4 (2025.06.20-2026.03.30)	Си Ай Ти ХХК	МУИС-ийн Байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж	456,545.00	45,654.50	410,890.50
MJEED-B5-20250210-P5 (2025.06.20-2026.03.30)	Голден Хоул ХХК	МУИС-ийн Байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж	599,939.00	59,993.90	539,945.10
MJEED-B5-20250210-P6 (2025.06.23-2026.03.30)	Интерсайнс ХХК	ШУТИС-ийн сургалт, судалгааны лабораторийн тоног төхөөрөмж	308,000.00	30,800.00	277,200.00
Дүн			2,754,875.00	275,487.50	2,479,387.50

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Инженер, технологийн дээд боловсрол төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төслийн үйл ажиллагааг сайжруулах сургалтын хөтөлбөрөөс хасагдсан оюутнуудын зээлийн эргэн төлөлт, зардлын ангилал, судалгаа дэмжих сангийн баримтын бүрдэл болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Г.Төрсайхан, туслах аудитор Б.Баттогтох нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Батчимэг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,544,502.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 55,445.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор “Хамтарсан судалгаа-Бизнес түншлэл 2025” олон улсын бизнес семинар арга хэмжээг тайлант онд зохион байгуулаагүй, батлагдсан төсвийн хүрээнд 56,430.5 мянган төгрөгийн гадаад албан томилолтын зардлыг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 8,024,167.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,986,669.8 мянган төгрөгийн 176 зарлагын гүйлгээ, 37,497.4 мянган төгрөгийн 3 орлогын гүйлгээний мэдээллийг тус тус байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байхаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАУХА тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 29,924.2 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 9,805,044.2 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	9,805,044.2	0	0.00	0.0
Албан шаардлага	1	29,924.2	1	29,924.2	100.0
Нийт дүн	2	9,834,968.4	1	29,924.2	50.0

Өмнөх онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн боловч тайлант онд уг зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Боловсролын сайдын тушаалаар зээлийн гэрээг дуусвар болгосон оюутнуудын зээлийн эргэн төлөлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, боловсролын зээлийн санд мэдээлсэн эсэхийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 527.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

Тайлант хугацааны эцэс дэх 52.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, 474.3 мянган төгрөгийн ажилчдаас авах авлагыг санхүү байдлын тайланд өглөгийн дүнд оруулан тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27 дугаар параграф, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт болон эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Аудитаар нийт 439,872.3 мянган төгрөгийн зөрчилд² 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 439,872.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлээрх зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 775.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

2. Оюутны зээлийн гэрээ дуусгавар болохтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсролын сайдын тушаалаар Япон Улсад суралцаж байсан 10 оюутантай байгуулсан зээлийн гэрээг цуцалснаас 6 оюутан нь тайлант онд зээлийн эргэн төлөлт хийгээгүй 438,282.7 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй. Зээлийн эргэн төлөлт хийгээгүй 4 суралцагчийн мэдээллийг Боловсролын зээлийн санд хүргүүлээгүй байна.

Энэ нь МУЗГ, Японы Олон Улсын Хамтын ажиллагааны Байгууллага /Жайка/-н хооронд 2014 оны 03 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан MON-P11 тоот зээлийн хэлэлцээр, БШУС-ын 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/308 дугаар тушаалаар батлагдсан "Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосэн,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам"-ын 2.11-д "ТУХ нь суралцагчийн улирал, жилийн эцсийн сурлагын дүнгийн голч оноо нь гэрээнд заасан дүнг хангахгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр цаашид үргэлжлүүлэн сурах боломжгүй болсон тохиолдолд суралцах үйл ажиллагааг зогсоох саналыг боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-н гишүүнд танилцуулж зохих шийдвэр гаргуулна", 2.12-т "Энэхүү журмын 2.11 дахь хэсэгт заасан шийдвэр гарсан суралцагчтай байгуулсан гэрээг цуцалж, суралцсан хугацааны зардлыг буцаан төлүүлнэ", ИТДБТ-ийн санхүүжилтээр Япон Улсад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 2.1.6-д "Суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зээлийн журмын дагуу буцаан төлж барагдуулаагүй нөхцөлд хуулийн байгууллагад хандан зээлийг төлүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээлийн эргэн төлөлт хийгээгүй суралцагчдын мэдээллийг боловсролын зээлийн санд шилжүүлж, зээлийн эргэн төлөлтийн талаар арга хэмжээг авч ажиллах.

3. Судалгаа дэмжих сангийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсын их дээд сургуулиудын хамтарсан судалгааг дэмжих зорилгоор судалгааны багуудад олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд судалгааны явцын тайланг хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", ИТДБ-н төслийн хүрээнд хийгдэх хамтарсан судалгааг дэмжих санхүүжилтийн тухай зөвлөмж "Төсвийн зарцуулалтын тайлан, судалгааны ажлын явц, үр дүнг бүрэлдэхүүн сургууль болон сургуулийн эрдэмтэн, судлаачдын зөвлөлөөр хагас жилд нэг удаа хэлэлцүүлж, үр дүнг тухай бүрт нь ТХН-д тайлагнана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Судалгааны явцын тайлан болон төсвийн зарцуулалтын тайланг хүлээн авч холбогдох хяналтыг хэрэгжүүлж байх.

4. Албан томилолтын зардалтай холбоотой

Илрүүлэлт: Дотоод томилолтоор тооцож олгосон шатахууны зардалд 814.6 мянган төгрөгийн и-баримт нь байгууллагын нэр дээр бус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-н 2 дугаар зүйлийн 2.10 "Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтын шатахууны зардлын анхан шатны баримтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант хугацааны эцэс дэх 52.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, 474.3 мянган төгрөгийн ажилчдаас авах авлагыг санхүү байдлын тайланд өглөгийн дүнд оруулан тайлагнасан	1	527.0			1	527.0	1	527.0				
	Дүн	1	527.0			1	527.0	1	527.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 775.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал гаргасан.	1	775.0					1	775.0				
Боловсролын сайдын тушаалаар Япон Улсад суралцаж байсан 10 оюутантай байгуулсан зээлийн гэрээг цуцалснаас 6 оюутан нь тайлант онд зээлийн эргэн төлөлт хийгээгүй 438,282.7 мянган	1	438,282.7					1	438,282.7				

Инженер, технологийн дээд боловсрол төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй. Зээлийн эргэн төлөлт хийгээгүй 4 суралцагчийн мэдээллийг Боловсролын зээлийн санд хүргүүлээгүй байна												
Монгол Улсын их дээд сургуулиудын хамтарсан судалгааг дэмжих зорилгоор судалгааны багуудад олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд судалгааны явцын тайланг хавсаргаагүй	1	0.0				1	0.0					
Дотоод томилолтоор тооцож олгосон шатахууны зардалд 814.6 мянган төгрөгийн сугалааны дугаартай баримт хавсаргасан	1	814.6				1	814.6					
Дүн	4	439,872.3				4	439,872.3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7,986,669.8 мянган төгрөгийн 176 мэдээлэл, орлогын 37,497.4 мянган төгрөгийн 3 мэдээллийг тус тус байршуулаагүй.	1	8,024,167.2			1	8,024,167.2				
Нийт дүн	1	8,024,167.2			1	8,024,167.2				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 390/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7,986,669,832.33 /Долоон тэрбум есөн зуун наян зургаан сая зургаан зуун жаран есөн мянга найман зуун гучин хоёр/ төгрөгийн 176 мэдээлэл, орлогын 37,497,391.55 /гучин долоон сая дөрвөн зуун ерэн долоон мянга гурван зуун ерэн нэгэн/ төгрөгийн 3 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Инженер технологийн дээд боловсрол төслийн зохицуулагч /Д.Намсрай/, санхүүгийн ажилтан /В.Батмөнх/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.ГҮНДБАЯР